



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 1296

Булган

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаал, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах болон хугацааг сунгах байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр авч байгаа байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, тушаал, зааварт тусгагдсаны дагуу хяналт тавьж, зөрчил дутагдал үүсэхээс сэргийлэх, үүссэн даруйд холбогдох арга хэмжээг авч ажиллахыг комисс /С.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж, тушаал, зааврыг баримтлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Э.Түвшинмөнх/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /С.Батболд/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *Л.Бад* З.БАТБОРИГ



194
Аймгийн Засаг даргын 2018 оны 05
сарын 16. -ны өдрийн 0296 дугаар
захирамжийн хавсралт

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР АВСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр	Гэрчилгээний дугаар	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Булган сумын "Цэвэрч бялзуухай" ХХК-ий ахуйн шавьж мэрэгч устгал, ариутгал, халдваргүйжүүлэх үйлчилгээ	АҮХ-18/04/307	2018/05/10	2021/05/10
2	Могод сумын "Хульж ресорт" сувиллын тусламж үйлчилгээ	СХ-18/04/352	2018/05/10	2021/05/10

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Гэрчилгээний дугаар	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Орхон сумын Эрүүл мэндийн төв	ЭУ-04/04/324	2018.01.24	2023.01.24
2	Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв	ЭУ-04/04/330	2018.01.24	2023.01.24